



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/531

Мөрөн сум

Газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мөрөн сумын Засаг даргын санал, иргэн Б.Мөнхсайханы ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/368 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх заалтаар иргэн Чулуут овгийн Батаагийн Мөнхсайхан (РЭ59042911)-д “Худалдаа, үйлчилгээний зориулалттай”-гаар эзэмшүүлсэн Мөрөн сумын 3 дугаар 1-25 тоотод байршилтай 6712014839 нэгж талбарын дугаартай 21709м² газрын зориулалтыг өөрчилж, “Үйлчилгээтэй орон сууц”-ын зориулалттай болгон үлдсэн 10 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/368 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх заалтын 4 дэх хэсгийг хүчингүй болгосугай.

3.Газар эзэмшигч иргэн Батаа овогтой Мөнхсайхан (РЭ59042911)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ